

ГОЛОМТ БАНК ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар
2025 он**

1.Үнэлгээний зорилго

- 1.1.Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3.Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2 – оос доошгүй удаа тооцно.
- 1.4.Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

2.Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	Нэгдсэн дун	72	72		100%

3.Үнэлгээний аргачлал

3.1.Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2.Үнэлгээний нэгдсэн дунд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1.авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

- 3.2.2.70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3.50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайн болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4.49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

4.Үнэлгээний асуулга

“Голомт банк” ХК

/нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайллагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бутэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банк нь ХЭХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 00/06 дугаар шийдвэрээр ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан. Журмаар ТУЗ-ийг хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын хэлбэр, дэг, ТУЗ-ийн шийдвэр, тэмдэглэл, гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийн зохицуулан ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааг зохицуулсан.</p> <p>Мөн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 00/33 тогтоолоор шинэчлэн батлагдсан Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрмийн 10.1 дэх хэсэгт ТУЗ-ийн гишүүд тодорхой тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаарх зохицуулалтыг тусгасан болно. /баримт бичгийг хавсаргав/</p>	2	
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны ТУЗ нь дэргэдээ 4 хороодтой үйл ажиллагаа явуулдаг. Үүний нэг нь “Нэр дэвшүүлэх” хороо юм. ТУЗ-2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 00/34 тогтоолоор шинэчлэн батлагдсан Нэр дэвшүүлэх хорооны дүрмийн 4 дүгээр зүйлд ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тогтооход ТУЗ-д туслах, холбогдох зөвлөмжийг боловсруулах талаар тусгасан. Мөн банкны Хүний нөөцийн бодлогыг ГУ-тай хамтран боловруулсан бөгөөд тус бодлогод банкны Залгамж болон удирдах ажилтныг тасралтгүй бэлтгэх, ажилтны сургалт хөгжил, карьерийн замнал зэрэг асуудлыг тусгасан байна. Энэхүү бодлогыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг ГУ-д өгсөн ба тус ХН бодлогыг хамгийн сүүлд 2024 оны 12 сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн 00/48 тоот Тогтоолоор шинэчлэн баталсан байна.</p>	2	

3	<p>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаже, цахим хуудсандaa байриуулна.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>www.golombank.com цахим хуудасны “Хөрөнгө оруулагчид” хэсэг болон 2024 оны Жилийн тайланда Голомт банкны ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдлын мэдээллийг тусгасан. Мөн тайлант хугацаанд ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа, хурлын давтамж зэрэг мэдээллүүд багтсан байна. Мөн банкны зохицуулалтын хүрээнд ТУЗ болон ХЭХ-ийн хурлын ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэрлэсэн байдал зэргийг дэлгэрэнгүй байдлаар зохицуулагч байгууллагад тухай бүр мэдээлж, мөн жилийн үйл ажиллагаа, засаглалын тайланд бүрэн тайлагнаж мэдээллийг хүргүүлж ажилласан байна. ХК болсноос хойшхи хугацаанд ТУЗ-ийн хурал болон хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ирц, ТУЗ-ийн ажлын тайланг жилийн тайланд мэдээлсэн бөгөөд улирал бүр ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг цахим хуудсандaa байршуулсан байна.</p>	2
4	<p>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон хороод тус бүрийн дүрмээр бүтэц, бүрэлдэхүүн болон холбогдох шаардлагыг тусгасан. Мөн хууль журмын дагуу ТУЗ-ийн Хараат бус гишүүн тус Аудит болон Эрсдэлийн удирдлагын хороодын Даргалдаг ба хороо тус бүр хариуцсан үүрэг хариуцлагынхаа хүрээнд шийдвэр гаргаж, ТУЗ-д зөвлөмж өгч, ГҮ-д үүрэг өгч хэрэгжилтийг хянаж ажилладаг. Мөн ТУЗ-ийн хурлаар үйл ажиллагааны тайлангаа тогтмол тайлагнаж ажилладаг. Тус хороодод хамгийн чухал тавигддаг шаардлага болох Хараат бус гишүүдийн оролцоог бүрэн хангасан ба ТУЗ-ийн Хараат бус гишүүд Аудит, ЭУХороонд гишүүнээр ажилладаг. ТУЗ-ийн Хороодын бүрэлдэхүүн www.golombank.com цахим хуудаснаа нээлттэй байршиж байна.</p>	2
5	<p>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны ТУЗ-ийн гишүүд нь 2024 онд засаглалын сэдэвийн хүрээнд “Компанийн Засаглалын Хүрээлэн” /The Corporate Governance Institute/-гээс зохион байгуулдаг дараах сургалтнаас сонгон хамрагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 1. Best Practice in ESG and Risk Management; 2. Digital Transformation for Directors; 3. Integrating ESG into Business Strategy; 4. Cyber Security for Directors. <p>Тус байгууллага нь дэлхийн хэмжээнд гүйцэтгэх удирдлагын болон удирдах зөвлөлийн түвшний захирлуудад сургалт, гэрчилгээ олгох чиглэлээр мэргэшсэн боловсролын байгууллага юм.</p>	2

6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицстой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Мөн шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд нь чиглүүлэх хөтөлбөрт хамрагддаг бөгөөд ХЭХ-аас шинэ сонгогдсон даруйд нь уг сургалтыг боломжтой үед нь зохион байгуулдаг. Уг сургалтын хөтөлбөр нь тухайн гишүүний мэргэжлийн ур чадвар, хэрэгцээнд нь тулгуурласан байна. Уг хөтөлбөр нь бусад асуудлаас гадна дараах асуудлыг заавал хамрах бөгөөд үүнд Банкны хууль, удирдлагын бүтэц, банкны дүрэм, засаглалын кодекс, банкны үйл ажиллагааны зохицуулалтууд, банкны үндсэн бодлого журмууд, ёс зүйн дүрэм, банкны зорилго, стратегийн бизнес төлөвлөгөө, банкны санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгийн удирдлага, банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа багтдаг. Хөтөлбөрийн хүрээнд мөн шаардлагатай мэдээллийг хүргэх гол ГҮ-ийн багийн гишүүдтэй уулзуулж өнгөрсөн болон ирээдүйд хийгдсэн ажлууд, төлөвлөгдж байгаа зүйлсийн талаар мэдээллийг хүргүүлдэг ба үндсэн салбарын үйл ажиллагааг танилцуулах газар дээрх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Мөн ТУЗ-ийн гишүүдийн зүгээс гишүүдийг өөрсдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, сургалтад хамрагдах явдлыг дэмжиж ажилладаг бөгөөд ТУЗ-ийн урьдчилсан зөвшөөрлийн үндсэн дээр уг сургалт болон зардлыг банкнаас хариуцаж ажилладаг.	2	
7	ДҮН ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ		12 100%		
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 00/34 тогтоолоор шинэчлэн батлагдсан Нэр дэвшиүүлэх хорооны дүрмийн 4.1.3 дах хэсэгт ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүний олонх нь хараат бус байх зорилтыг тусгасан. 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭ-ийн ээлжит хурлаар шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгон шалгаруулан нэр дэвшиүүлж тус хурлын 00/03 дугаар	2	

			шийдвэрээр 5 хараат бус, 4 энгийн гишүүн буюу дийлэнх нь хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй болсон. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Мөнхцэцэг нь ердийн гишүүн юм. Харин ТУЗ-ийн хороодын дарга нар ТУЗ-ийн хараат бус гишүүн байх ба тус хороодын дийлэнх гишүүдийг Хараат бус гишүүдээр бүрдүүлсэн байна. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн дарга болон бүрэлдэхүүний олонх нь хараат бус гишүүд байна.	
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны дүрмийг ТУЗ-ийн 2024 оны 00/42 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан. Дүрэмд бүтэц, зохион байгуулалт, хурлын дэг, хороо болон гишүүдийн эрх үүрэг зэргийг зохицуулсан. 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 00/30 тоот ТУЗ-ийн тогтоолоор өөрчлөн батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б. Дваер томилогдон ажиллаж нийт 5 гишүүний 3 гишүүн нь хараат бус байна. Тус дүрмийн 3.7 дох заалтад компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад ажилтнууд хорооны даргын зөвшөөрөлтэй орох тухай заасан байна.	2
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцно.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 00/33 тоот тогтоолоор Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрмийг шинэчлэн баталсан. Тус дүрмийн 2 дугаар зүйлд ТУЗ-ийн бүрэлдэхүүний цалин урамшууллыг тогтоох талаар тусгасан бөгөөд тооцох зарчмыг мөн тусгасан. ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 00/30 тоот тогтоолоор өөрчлөн батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ЗЁЦҮХ-ны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б. Дваер томилогдон ажиллаж байна. Тус хорооны дүрмийн 9.6-д шаардлагатай тохиолдолд хуралд холбогдох нэгжийн удирдлагыг оролцуулж тайлбар, тодруулга авч болох талаар тусгасан байна.	2
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 12 сарын 27-ны өдрийн 00/34 тоот тогтоолоор шинэчилсэн баталсан Нэр дэвшүүлэх хорооны дүрмийн 4 дүгээр зүйлд хорооны чиг үүргийн талаар заасан ба үүнд ТУЗ-ийн хараат бус болон ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх үйл ажиллагаа, залгамж халааны бодлогыг тусгасан байна. ТУЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 00/30 тоот тогтоолоор өөрчлөн батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер томилогдон ажиллаж байна.	2
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Засаглал, ёс зүй, цалин	2

		<p>байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд уйл ажиллагааны журам, заавартай, чиг үүрээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилаа бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	урамшууллын хороод тус бүр өөрийн батлагдсан дүрэмтэй бөгөөд мөн батлагдсан бүрэлдэхүүнтэй. ТУЗ, түүний хороод, тэдгээрийн чиг үүрэг болон ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршилаа, мэдлэг, ур чадварын талаар банкны цахим хуудсанд оруулсан.	
--	--	--	---	--

		ДҮН	10	100%
--	--	-----	----	------

ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

12	<p>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны Засаглалын кодексын Аудит ба тайлагнал бүлэгт нийтэд хүргэх мэдээллийн жагсаалтыг баталсан. Тайлант хугацаанд хамаарах зохицуулагчийн Зохистой засаглалын журмын дагуу санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг ил болгодог ба Голомт банкны Мэдээллийг бодлого, Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, ГБ нягтлан бодох бүртгэлийн бодлого, мэдээллийн ангилал, нууцыг хамгаалах, зохистой хэрэглээний журмуудын дагуу мэдээллүүдийг тодорхойлж нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журмын дагуу цахим хуудас, жилийн тайлан, зохицуулагчид тус тус тогтмол тайлагнаж, хянадаг.</p>	2	
13	<p>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p>	Хэрэгжсэн	<p>Банкны цахим хуудсанд дараах мэдээллүүд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Засаглалын тайлан https://golomtbank.com/investor-relations/governance-report - Хувьцаа эзэмшигчдийн бүтэц https://golomtbank.com/investor-relations/governance - ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба товч намтар https://golomtbank.com/investor-relations/board-of-directors - ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан https://golomtbank.com/about-bank/board-of-committee - ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг https://golomtbank.com/about-bank/board-of-committee - Удирдлагын баг https://golomtbank.com/about-bank/executive-management - Компанийн бүтэц https://golomtbank.com/about-bank/management/bank-structure - Компанийн засаглалын бүтэц https://golomtbank.com/investor-relations/governance/corporate-governance-structure 	2	

	<ul style="list-style-type: none"> - Комплаенс https://golomtbank.com/about-bank/management/compliance - Дотоод хяналтын талаар мэдээлэл https://golomtbank.com/investor-relations/governance/internal-control - Жилийн санхүүгийн тайлан https://golomtbank.com/investor-relations/audited-financial-report - Улирлын санхүүгийн тайлан https://golomtbank.com/investor-relations/season-report - Жилийн үйл ажиллагааны тайлан https://golomtbank.com/investor-relations/year-report - Тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл https://golomtbank.com/investor-relations/sustainable-development - Тогтвортой хөгжлийн тайлан https://golomtbank.com/investor-relations/sustainable-development/report <p>зэрэг мэдээллүүд монгол, англи хэл дээр нийтлэгдсэн. Цаашид бид цахим хуудсаа улам хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах, зохицуулагч байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд тавьж буй шаардлагыг биелүүлж ажиллахаар төлөвлөж байна.</p>			
14	<p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлоөлж болзошгүй хучин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>2024 оны Голомт банкны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт хангалттай цэвэр гарсан ба ямар нэгэн санхүүгийн хүндрэлтэй байдалд орж болзошгүй зүйл байхгүй болно. Санхүүгийн бус тайлагналын хүрээнд 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд эдийн засгийн орчин, хөрөнгийн зах зээл, жижиг дунд бизнесийн салбар, олон улсын бизнес харилцаа, тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлага, эрсдэлийн удирдлага, комплаенсын талаарх тайлан, мэдээ, мэдээллийг оруулсан. Мөн тогтвортой хөгжлийн тайланг тусад нь бэлтгэн нийтэлдэг. Голомт банк нь Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийн лимитүүдийг баталдаг ба эдгээрт санхүүгийн, санхүүгийн бус үйл ажиллагааны зэрэг бүх төрлийн үзүүлэлтүүд багтдаг. Эдгээрийг тухай бүр стратегитай уялдуулан шинэчлэн баталдаг ба баталсан лимитүүдийн хэрэгжилтийг улирал бүр ТУЗ-д тогтмол тайлагнахаас гадна өөрийн цахим хуудсандaa Хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргүүлэх зорилгоор тус буланд “Тайлан, мэдээ” цэсээр дээр дурдсан санхүүгийн болон санхүүгийн бус тайлангуудыг тогтмол байршуулдаг.</p>	2
ДҮН			6	

ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

100%

15	<p>4.1. ТҮЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Аудитын хорооны дурмийн 4.2.26-4.2.38-д хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг тусгасан байдаг.</p> <p>4.2.26 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хараат бус байдлыг хангах тухай журам гаргаж, мөрдөх</p> <p>4.2.27 Хөндлөнгийн аудитын байгууллагын ажлын саналд тусгагдсан аудитын хамрах хүрээг батлах, арга аргачлалыг хянах,</p> <p>4.2.28 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх болон төлбөрийн тухай саналыг ТҮЗ-д гаргах,</p> <p>4.2.29 Хөндлөнгийн аудитын байгууллагаас үзүүлэх аудитын бус үйлчилгээтэй холбоотой тайлан мэдээг сонсох, аудитын бус үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргах,</p> <p>4.2.30 Хөндлөнгийн аудитын байгууллагын ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх,</p> <p>4.2.31 Хөндлөнгийн аудитын байгууллагыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нөөц, нөхцөл бололцоогоор хангах,</p> <p>4.2.32 Хараат бус байдал нь алдагдах эрсдэл бий эсэх талаар хөндлөнгийн аудитын байгууллагатай жил бүр хэлэлцэх,</p> <p>4.2.33 Хөндлөнгийн аудитын байгууллагын батаалгаажуулсан санхүүгийн тайлан болон аудит хийх үед үүссэн аливаа хүндрэлийг хэлэлцэж, аудитын тайлан, санал зөвлөмжийг ТҮЗ-д танилцуулах,</p> <p>4.2.34 Тогтмол хугацаанд хөндлөнгийн аудиторуудтай уулзаж, хороо болон хөндлөнгийн аудиторууд Удирдлагын багаас тусдаа хэлэлцэх асуудал бий эсэхийг нягтлах, уулзалтад Аудит хариуцсан захирлыг оролцуулах,</p> <p>4.2.35 Санхүүгийн тайлагналтай холбоотой Удирдлага болон хөндлөнгийн аудиторын маргааныг эцэслэн шийдэх</p> <p>4.2.36 Хөндлөнгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих,</p> <p>4.2.37 Банк нь баримт, материалуудыг хадгалахдаа баримт хадгалах журмыг мөрдөж буй эсэхэд хяналт тавих,</p> <p>4.2.38 Олон улсад мөрдөгдөж буй, шинээр гарч буй аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаар тогтмол мэдээлэлтэй байх.</p>	2
16	<p>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн элжсит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан ХЭХ-д KPMG хөндлөнгийн аудитор оролцон танилцуулах илтгэл тавьж хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлсэн. Хөндлөнгийн аудитын байгууллагаас 2023 оны банкны санхүүгийн тайлан нь СТОУС болон НББОУС-уудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэж дүгнэсэн бөгөөд бүх төрлийн баримт нотолгоогоор батлагдсан болно.</p>	2

17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг Банкны жилийн тайлан дээр жил бүр тусгахаас гадна эдгээр мэдээллийг цахим хуудаст байнга байршуулан, өөрчлөлт орох бүрт шинэчилж байна. Тус мэдээлэл нь мөн банкны 2024 оны жилийн тайланд туссан болно. https://golomtbank.com/wp-content/uploads/2025/02/20241231%D0%96%D0%AD%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD_vF.pdf	2	
----	---	--------------------	---	---	--

	ДҮН	6	100%
--	-----	---	------

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохицой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Эрсдэлийн удирдлагын газар нь 2007 оны 09 сард байгуулагдаж, газрын үйл ажиллагааны анхны дүрэм 2007 оны 09-р сарын 10-ны өдрийн 378 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан ба сүүлийн байдлаар 2024 оны 02-р сарын 28-ны 119 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэгдэн батлагдсан. Эрсдэлийн удирдлагын газар нь ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд шууд тайлагнадаг. Гүйцэтгэх удирдлагын Эрсдэлийн удирдлагын хорооны ажлын албан нь Эрсдэлийн удирдлагын газар бөгөөд гүйцэтгэх дээд удирдлагад эрсдэлтэй холбоотой асуудлуудыг тогтмол тайлагнаж ажилладаг. Банкны мөрдөх эрсдэлийн лимит, хязгааралтуудыг тогтоосон Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл (RAS)-ийг шинэчлэн баталсан. Эрсдэлийн удирдлагын газар нь 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 5 хэлтэстэйгээр банкны эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p> <p>ТУЗ-өөс баталсан Эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу эрсдэлийн улирдагын үйл ажиллагааг явуулдаг. Эрсдэлийн удирдлагын газар нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан ТУЗ-д банкны эрсдэлүүдийг тайлагнаж, эрсдэлийн хязгаарлалтуудыг батлуулдаг. Зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, МУТСТ, хянан нийцүүлэх, эдийн засгийн зэрэг эрсдэлүүдийн хүрээнд Эрсдэлийн удирдлагын тайланг бэлтгэн жилд 4 удаагаас доошгүй удаа Эрсдэлийн удирдлагын хороог хуралдуулж байна. Мөн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын хэмжээнд банкны Эрсдэлийн удирдлагын хороо сар бүр хуралдаж эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажилладаг.</p>	2	
----	--	--------------------	---	---	--

	5.2. ТУЗ нь дэргэдээ зэрдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Эрсдэлийн улирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер томилогдон ажиллаж байгаа бөгөөд гишүүдээр Роберт В. ван Звитен /Хараат бус гишүүн/, Жеймс Б. Дваер /Хараат бус гишүүн/, Ч.Мөнхцэцэг, Ж.Үнэнбат нар ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэмд ТУЗ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өлрийн 00/46 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Тус хорооны чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, тухайн тайлант жилд хэлэлцсэн асуудлууд, хуралдсан хурлын тоо, баталсан баримт бичгүүдийн талаар товч тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан-компанийн засаглал хэсэг болон цахим хуудсаар тогтмол тайлagnадаг. ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын тайланг улирал бүр банкны цахим хуудсанд мэдээлдэг ба энэ нь харата бус гишүүдийн даргалдаг, оролцдог хороодын хурлын давтамж, хэлэлцсэн асуудал зэрэг мэдээллийг агуулдаг.	2	
19	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр зэрдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банк 2019 оны 9-р сарын 22-ны өдөр АНУ-ын Нью Йорк хотноо “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч банкнуудын нэг болж, өөрийн үйл ажиллагааг “Тогтвортой хөгжлийн зорилтууд” болон “Парисын гэрээний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтууд”-тай уялдуулан ажиллахаа тунхагласан. Үүнтэй холбоотойгоор Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 434 тоот тушаалаар “Тогтвортой хөгжлийн бодлого”, 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1246 тоот тушаалаар “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх дотоод журам”-ыг тус тус шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Мөн жил бүр “Тогтвортой хөгжлийн тайлан”-г боловсруулан, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэж байна. https://golombank.com/investor-relations/sustainable-development/report	2	
20			Нийгмийн хариуцлагын хүрээнд Үнэт өв, эрүүл мэнд, боловсрол, урлаг соёл гэсэн 4 ундсэн чиглэлийг дэмжиж ажилладаг.		
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банк нь Комплаенсийн хэлтсийг 2016 оны 3 сард байгуулсан бөгөөд тус хэлтэс нь Ерөнхийлөгчийн харьянд үйл ажиллагаагаа явуулдаг. Хэлтэс нь үйл ажиллагаандаа ТУЗ-ийн 2022 оны 6-р сарын 21-ний өдрийн 00/21 тоот тогтоолоор батлагдсан Комплаенсийн бодлогыг мөрдөж ажилладаг бөгөөд банкинд хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Комплаенсийн хэлтсээс улирал бүр ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд Мөнгө угаах, терроризмыг	2	

санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон Комплаенсийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хараат бусаар тайлагнадаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ нэгж нь Ерөнхийлөгчийн удирдлаганд нийт 9 орон тоотойгоор ажиллаж байна. Хэлтсийн захирал Н.Мөнхжаргал нь МУТСТ чиглэлээр 18 жил ажилласан туршлагатай ба 2011 онд Люксембург хотноо CAMS шалгалтыг амжилттай өгсөн ба 2019 онд дахин амжилттай баталгаажуулсан.

ТУЗ-н Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал тутам Комплаенсийн/МУТСТ/ үйл ажиллагааны явц, нөхцөл байдал, эрсдэл, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээ авахыг үүрэг болгон, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг болно.

Банкны Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аргаар банкны нэгжүүдийг хялан шалгадаг ба эрсдэл бүхий нэгжүүдийг жилд 1 удаа шалгах бодлого баримтлан хэрэгжүүлж ТУЗ-н дэргэдэх Аудитын хороогоор гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажилладаг.

Банк тухайн жилд Комплаенсийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлж, бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, гүйцэтгэлийг хагас жил тутам Гүйцэтгэх захирал, банкны Ерөнхийлөгчийн түвшинд хяналт тавьж ажилладаг болно.

Комплаенсийн хэлтэс нь дээрх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж сар бүр Санхүүгийн удирдлагын газарт гүйцэтгэлийг хэмжих тусгай журам арга аргачлалын дагуу тусгай системд бүртгэж тайлагнаж ажилладаг болно.

Банкны Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аргаар банкны нэгжүүдийг хялан шалгадаг ба эрсдэл бүхий нэгжүүдийг жилд 1 удаа шалгах бодлого баримтлан хэрэгжүүлж ТУЗ-н дэргэдэх Аудитын хороогоор гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажилладаг. Голомт банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (цаашид “МУТС” гэх)-тэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь дараах баримт бичгээр заагдсан тогтолцооны дагуу хэрэгжиж байна. Үүнд:

1. Банкны ТУЗ-өөс баталж, мөрдүүлж буй зохицуулалтууд:

1.1. “Эрсдэлийн Удирдлагын Тогтолцоо / Эрсдэлийн Аппетитийн Тунхаглал” бодлогын баримт бичиг;

1.2. “Эрсдэлийн Аппетитийн Мэдэгдэл” – Эрсдэлийн лимит хязгаарлалтууд;

1.3. “Эрсдэлийн таксономи” – Эрсдэлийн ангилал, хариуцсан хамгаалалтын бүсүүд;

	<p>1.4. “Голомт банкны Комплаенсийн Бодлого”;</p> <p>1.5. “Голомт банкны ёс зүйн кодекс”;</p> <p>1.6. “Эрсдэлийн удирдлагын бодлого”;</p> <p>2. Гүйцэтгэх удирдлага болон Комплаенс хариуцсан нэгжийн зүгээс баталж, мөрдүүлж буй зохицуулалтууд:</p> <p>2.1. “МУТСТ үйл ажиллагааны журам”;</p> <p>2.2. “МУТСТ сэжигтэй гүйлгээг хянах, СМА-д мэдээллэх үйл ажиллагааны стандарт, түүнийг хэрэгжүүлэх заавар”;</p> <p>2.3. МУТСТ эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гарын авлага;</p> <p>2.4. “Эцсийн өмчлөгчийг тодорхойлох гарын авлага”;</p> <p>2.5. УТНБЭ-ийг тодорхойлох, хянах мэдээлэх заавар;</p> <p>2.6. “Харилцагч танъж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх гарын авлага”;</p> <p>2.7. “Харилцагчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх заавар”;</p> <p>2.8. “Корреспондент банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх заавар”;</p> <p>2.9. “Бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг хүргэх арга хэлбэрийн комплаенсийн эрсдлийг үнэлэх заавар”;</p> <p>2.10. “МУТСЭрсдэлийн нэгдсэн үнэлгээний түр аргачлал”;</p> <p>2.11. (2.1)-н хүрээнд банкны харилцагч бүртгэх, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх болон бусад дотоод процесс үйл ажиллагааны зохицуулалтын журам, стандарт, заавар, гарын авлагууд;</p> <p>Дээрх журам зааврыг бүрэн хэрэгжүүлэх зорилгын хүрээнд холбогдох нэгжүүд шат шатны сургалт хийхийн хамт, дижитал сургалтын материал бэлдэх, сургалт болгоны дараа холбогдох шалгалтуудыг авч үр дүнг ХНУГ-аас тодорхойлон ажилладаг болно.</p> <p>Мөн Комплаенсийн хэлтсээс хагас жил бүр мэдлэг шалгах түвшин тогтоо шалгалт авдаг ба жил ирэх бүр шалгалтын цар хүрээ, тест авах аргачлал зэргийг сайжруулан ажиллаж байна.</p> <p>ТУЗ нь улирал бүр МУТСТ үйл ажиллагааны тайлантай дэлгэрэнгүй танилцаж, банкны МУТСТ үйл ажиллагаанд чухал ач холбогдол өгөн шаардлагатай чиглэл үүрэг, зохистой шийдвэрийг тухай бүр гарган ажиллаж байна. Мөн эрсдэлийн үнэлгээний тайланг хэлэлцэж, үнэлгээний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу үүрэг өгч, түүний хэрэгжилтийг хянаж ажилладаг. Хамгийн сүүлд 2024.03.28-ны өдөр 2024 оны эхний улирлын тайланг танилцуулж зөвлөмж, чиглэл авсан.</p>	
--	--	--

		<p>Мөн банкны Комплаенсийн хэлтэс нь эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах үндсэн чиглэлээр тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Банкны нийт МУТС эрсдэлийн нэгдсэн үнэлгээний түр аргачлалыг дэлхийн банкны стандартын дагуу боловсруулан батлуулан, эрсдэлийн үнэлгээг хийв; - Корреспондент банк, бусад санхүүгийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийх; - Банкны бүтээгдэхүүн үйлчилгээнд онцлон МУТСТ эрсдэлийн дүгнэлт гаргах; - Шинээр зах зээлд гаргаж байгаа эсхүл өөрчлөлт орж буй бүтээгдэхүүн үйлчилгээнд эрсдэлийн дүгнэлт гаргах; - Нийт харилцагчид МУТСТ эрсдэлийн үнэлгээ хийх системийн тохиргоо, өгөгдлийн чанарыг удирдах; <p>Шаардлагатай ахисан түвшний судалгаа, гүйлгээний хяналтыг тогтмол хэрэгжүүлэх гэх мэт;</p>	
--	--	--	--

ДҮН

8

100%

ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банкны 2025 оны 04 сарын 17-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо ТУЗ-ийн тайланг төсвийн хамт хэлэлцэн ХЭХ-ийн 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 00/03 тоот шийдвэрээр батлагдсан.	2	
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 00/33 тоот тогтоолоор Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрмийг шинэчлэн баталсан. Тус дүрмийн 3 дугаар зүйлд Гүйцэтгэх улирдлагын багийн гишүүдийн цалин урамшууллыг тогтоох талаар тусгасан Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 959 тоот тушаалаар "Цалин хөлсний журам"-ыг шинэчлэн баталсан. Ажилтнуудын цалин нь албан тушаалын түвшин, албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэж буй ажлын цар хүрээ, ажилтны ур чадвар, гүйцэтгэлийн үнэлгээ зэргээс хамааран ялгаатай байдаг. Банкны цалин хөлсний систем нь шударга, үл ялгаварлах, нууцлалтай, нэгдмэл нэг системтэй, хуульд нийцсэн зарчмуудыг баримталдаг.	2	

Мөн Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1315 тоот тушаалаар батлагдсан "Голомт банкны төвийн нэгж

			болон салбар, тооцооны төвийн гүйцэтгэлийн удирдлагын журам” Гүйцэтгэх захирлын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 1025 тоот тушаалаар батлагдсан “Төвийн нэгжийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журам”, Гүйцэтгэх захирлын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 1116 тоот тушаалаар батлагдсан “Салбар нэгжийн ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журам”-ыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна. Энэхүү журмын дагуу ТУЗ-аас баталсан бизнес төлөвлөгөө, зорилго, стратегитай уялдуулан нэгжүүдийн зорилго, зорилт, КРІ үзүүлэлтүүд батлагддаг. Энэхүү журмын дагуу хагас жилд нэг удаа, Банкны гүйцэтгэл 85%-иас дээш, нэгжийн гүйцэтгэл 75%-иас, ажилтны гүйцэтгэл 80%-иас дээш тохиолдолд урамшуулал олгодог.		
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хэрэгжүүлсэн	Tайлант хугацаанд Голомт банкны зохицуулалтийн хүрээнд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, бусад урамшууллыг, олгох гүйцэтгэлийн шалгуурыг ГЗ-ийн хамт ТУЗ-өөс баталж, гүйцэлгэлийг хянаж ажилласан. Энэ тухайгаа зохицуулагч байгууллага, шат дараалсан эрх бүхий этгээдүүдэд нээлттэй тайлагнаж, хууль журмын шаардлагыг хангаж ажилласан байна. Голомт банкны жилийн тайланд цалин урамшууллын баримтлах бодлогыг ерөнхийлөн тусгаж ажилласан. Мөн Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрмийн 3 дугаар зүйлд цалин урамшууллын бодлогыг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих тухай заасан бөгөөд тухайн чиг үүргийг жилийн тайланд мөн оруулсан байдал.	2	
ДҮН			6	100%	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.				
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банкны дүрэм, банкны засаглалын кодекс-д компанийн оролцогч талуудын харилцааг тусгаж, зохицуулалт оруулсан байдаг. Мөн зохицуулагчийн зохистай засаглалыг хэрэгжүүлэх хууль дүрмийн дагуу тайгнал болон томилгоог гүйцэтгэж ажилладаг. ХЭХ, ТУЗ, ГУ-ийн бүрэн эрх, шийдвэр гаргах хэм хэмжээг банкны дүрэм, засаглалын код болон бусад дагалдах дүрэм журмуудад тусгасан байна. Мөн шийдвэр гаргах эрхийн матрицийг ерөнхий шийдвэр талаар хууль комплаенсийн хэлтсүүд гаргаж мөрдөхөд дэмжиж ажилладаг, зээл талаас ТУЗ-ийн баталсан зээлийн бодлого, зээлийн хорооны дүрмийн хавралтаар баталж байдаг. Эдгээрийн хэрэгжилтийг хянаж тухай бүр холбогдох тайлангуудыг хургуулж, хэлэлцэн ажиллаж байна.	2	

	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудал голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банкны жилийн тайланд Голомт банкны баримталсан үндсэн стратеги, ХЭ-ийн бүтэц бүрэлдэхүүн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан бодлого, тайлант хугацаанд баримталсан стратеги, анхаарсан асуудал, гаргасан шийдвэрүүдийн тухай тайлагнадаг. Мөн төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэн, тухай бүр өгсөн үүрэг зөвлөмжийн биелэлт, ерөнхий үйл ажиллагааны үнэлгээ, ГУ-ийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийж ажилладаг.	2	
26	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харицаах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл, Банк эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, Дотоод хяналтын тогтолцоо, Засаглалын тогтолцоо, Санхүүгийн тайлангийн тайлагнал, Хэлцэлийн талаар толилуулах, Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээлэх, Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд зэрэг мэдээллийг банкны үндсэн вебсайтад олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан бөгөөд өөрчлөлт орсон тохиолдол тухай бүрд шинэчилдэг.	2	
27	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшилүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Голомт банк нь дараах баримт бичгүүдээр батлагдсан зохицуулалтын хүрээнд дотоод зөрчлийн асуудлуудыг хүлээн авч, шийдвэрлэж ажилладаг. Эдгээр зохицуулалтуудыг хамруулсан банкны шинэ ажилтанд болон нийт ажилтнуудад зориулсан сургалт, мэдлэг бататгах шалгалтууд тодорхой давтамжтай зохион байгуулагддаг. 1. Голомт банкны ТУЗ-ийн 2014.03.28-ны өдрийн 00/08 тоот тогтоолоор батлагдсан “Голомт банкны засаглалын кодекс”-н “Зөрчлийн тухай мэдээлэх бодлого” бүлэг; - Хавсралт 1 2. Голомт банкны ТУЗ-ийн 2022.06.21-ны өдрийн 00/21 тоот тогтоолоор батлагдсан “Голомт банкны Комплаенсийн бодлого”-ын (2.6)-р заалт; - Хавсралт 2 3. Комплаенсийн хэлтсээс Банкны нийт нэгж, ажилтнуудад зориулан гаргасан “Зөрчлийг мэдээлэх заавар” – Хавсралт 3 Мөн ажилтан санал хүсэлт, гомдлоо нэгжийн удирдлага болон ХНУГ-т хүргэдэг. Энэхүү процесс нь дээрх баримт бичгүүдээр зохицуулагдахаас гадна салбар тооцооны төв болон төвийн нэгжийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулалт олгох журам, цалин хөлсний журамд тус тус тусгагдсан байdag. Гүйцэтгэх захирлын 2021 оны 502 тоот тушаалаар Ажилтанд нийгэм ахуйн хөнгөлөлт үзүүлэх, тэтгэмж олгох журмын шинэчлэн баталсан ба банкны нийт ажилтнуудын нийгэм, ахуйн асуудлуудыг шийдвэрлэдэг.	2	
28					

			Гүйцэтгэх захирлын 2022 оны 1006 тоот тушаалаар Сургалт хөгжлийн журам шинэчлэн батлагдсан ба ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлагыг тасралтгүй сайжруулах, хөгжүүлэх зорилгоор банкны сургалт хөгжлийн хэрэгцээ тодорхойлох, сургалт хөгжлийн хөтөлбөр зохион байгуулах, сургалтыг үнэлэх болон бусад харилцааг зохицуулдаг. Банкны ур чадварын матрицтай уялдуулсан сургалт хөгжлийн моделийн дагуу ажилтнууд бэлтгэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг.		
			ДҮН	8 100%	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлжс, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны алсын хараа - Дэлхийн жишиг Монголын банк. Эрхэм зорилго - Хөгжлийн голомт. Уриа - Сайн сайхныг санхүүжүүлнэ. Үнэт зүйлс: Шударга зарчимч байх, Бууж өгөхгүй байх, Хариуцлагатай байх, Хамтаж сэтгэлгээтэй байх, Хайрцагнаас гарч сэтгэ, Хувь нэмрээ оруул, Чин хүсэлт эрмэлзэлтэй байх, Харилцагч төвтэй байх. Голомт банкны ТУЗ нь Ёс зүйн кодыг баталсан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Засаглалын кодекс нь Голомт банкны засаглалын тунхаг бичиг баримт ба түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэгт банкны ёс зүйн код багтдаг. Энэхүү мэдээллийг бид оролцогч талууд, хамтран ажиллагсдад ил тодоор мэдээллэж засаглалын зарчмыг танилцуулдаг.</p> <p>Байгууллагын соёл, дотоод эерэг уур амьсгалыг бэхжүүлэх болон нийт ажилтчдын дагаж мөрдөн үйл ажиллагаандaa баримтлах чухал засаглал болон соёлын бодлогын баримт бичиг болох "Code of Conduct"-ийг ТУЗ-өөс санаачлан баталсан. Шинэ санаачилгыг дэмжих, олон улсын туршлагыг судлах хүрээнд ТУЗ нь банкны "Code of Conduct"-ийг 18 зүйлтэй, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт 2023 оны 12 дугаар сарын 28-ны тогтоолын хавсралтаар баталсан</p>	2	
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үзээгчийн" тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банк нь "Шүгэл үлээх тогтолцоо"-той бөгөөд и-мейл, утас, хайрцаг, биечлэн уулзах зэрэг 4 төрлийн сувгуудаар хүлээн авч байна. Шүгэл үлээх сувгаар ирүүлсэн мэдээлэлд баталгаажуулалт хийхдээ мэдээлэгчийн нууцлалыг маш сайн хадгалдаг. Шүгэл үлээх сувгаар ирсэн мэдээллийг тусгай санд бүртгэдэг бөгөөд тус санд Аудитын хорооны дарга, Аудит хариуцсан захирал, Комплаенсийн хэлтсийн захирал хандах жрхтэй байдаг. Мэдээллийн дагуу хийгдсэн баталгаажуулалтын талаарх</p>	2	

			мэдээллийг улирал бүр Дотоод аудитын үйл ажиллагааны тайланд тусгадаг ба Аудитын хороонд тайлагнадаг.		
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх/өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны Засаглалын кодекс нь дараах бүлгүүдээс бүрдэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Голомт банкны засаглалын бүтэц 2. Голомт банкны ёс зүйн код 3. Голомт банкны авлигын эсрэг бодлого 4. Сонирхлын зөрчилтэй асуудал шийдвэрлэх журам 5. Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого 6. Луйврын эсрэг бодлого 7. Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого 8. Зөрчлийн тухай мэдээлэх бодлого <p>Эдгээр бодлого, журмуудын дагуу Банкны ажилтнуудад хээл хахууль, авилга өгөх, хүлээн авах, түүнд оролцохыг хориглодог. Мөн Голомт банк нь аливаа улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байх ерөнхий бодлогыг баримтлахаас гадна Голомт банкнаас болон Голомт банкны нэрийн өмнөөс улс төрийн нам, эвсэлд аливаа хэлбэрийн хандив өгөхийг хатуу хориглодог.</p>	2	

ДҮН

6 100%

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банкны www.golomtbank.com цахим хуудас нь монгол англи хэл дээр идэвхтэй ажилладаг ба үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүд, жилийн үйл ажиллагааны тайлан, тогтвортой хөгжлийн тайлан, засаглалын зохион байгуулалт, санхүүгийн байдлын талаарх тайланг жилээр болон улирлаар тайлагнан ажилладаг ба бүтээгдэхүүн болон цаг үеийн мэдээллийг шуурхай тухай бүр хүргэхийг зорьдог. Голомт банкны ХЭХ-ийн бүтэц, эзэмшлийн хувь хэмжээ, ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн хороодын мэдээлэл, Голомт банкны бүтэц zuраглал зэрэг засаглалтай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчилж цахим хуудаснаа байршуулж ажилладаг.</p>	2	
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хотолбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Голомт банк нь тайлант хугацаанд хувьцаа эзэмшигч нартай харилцах тогтолцоог хууль журмын дагуу бий болгосон ба жил бүрийн сүүлээр дараагийн жилийн ажлын төлөвлөгөө, ээлжит хурлын товуудыг гаргаж оролцогч талуудад мэдээллийг хүргүүлж ажилладаг. Мэдээлэл гаргах хугацаа, суваг зэрэг харилцаа төлөвлөгөө хөтөлбөр байдлаар гарч хэрэгжүүлдэг.</p> <p>Голомт банк нь нээлттэй ХЖ болсноосоо хойш хувьцаа эзэмшигчидтай харилцах, гомдол санал хүлээн авах сувгуудаа сайжруулахыг эрмэлзэж 2024 онд Хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтсийг үүсгэн</p>	2	

34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцөлийг бурдүүлнэ.</p>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>байгуулсан. Мөн ТУЗ-ийн түвшинд Хөрөнгө оруулагчидтай харилцах ТУЗ-ийн НБД, Хөрөнгө оруулалтын менежер зэрэг албан тушаалтнууд байх бөгөөд банкны хувьцаа эзэмшилтэй холбоотой санал, асуулт, гомдлыг биечлэн хүлээн авч уулзах, цахимаар хүргүүлэх сувгуудаар дамжуулан үйл ажиллагаандaa анхааран ажиллаж байна.</p>	2	
35	<p>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, омчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</p>	Бүрэн хэрэгжсэн	<p>Хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцох, санал өгөх, асуулт асуух эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцөлөөр хангах үүднээс хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, урьдчилан санал авах цахим системийг хөгжүүлсэн ба үүгээрээ дамжуулан санал өгөх зааварчилгаа, хурлын материалыг байршуулан мэдээлэл авах боломжоор ханган ажилласан. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдэд хурал болохоос өмнө хууль дүрмэнд заасан хугацаанд мэдээлэл, зар хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус аливаа хурал, санал хураалтыг зарласан ТУЗ-ийн Тогтоолд Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл зарыг хүргүүлсэн байх сүүлчийн огноог тавьж өгдөг ба энэхүү үүрэг хэрэгжиж байгаа эсэхийг Дотоод аудитын засаглалын тогтолцооны шалганаар хянадаг болно. 2025 оны ХЭ-ийн ээлжит хурлын мэдээллийг хууль, журмын хүрээнд 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болгон олон нийтэд МХБ болон Голомт банкны цахим хуудас, мэдээллийн сайтуудаар хүргэсэн. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүнийн сонгон шалгаруулалтын зарыг 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр банкны өөрийн цахим хуудаснаас гадна 9 мэдээ, сонингийн сувгаар олон нийтэд зарлаж 14 хоногийн хугацаанд нэр дэвшигчдийн анкетуудыг хүлээн авсан. Хуралтай холбоотой аливаа асуулт, саналыг и-мэйлээр болон лавлах утсаар нээлттэй хүлээн авч, шийдвэрлэн ажилласан.</p> <p>Голомт банкны дурмийн 4.1.1, Голомт банкны засаглалын кодексийн 1.1 Хувьцаа эзэмшигчдийн эрх хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүдээс гадна Банкны удирдлага, хяналтанд оролцох эрх, Банкны үйл ажиллагааны мэдээлэл авах эрх, болон Хувьцаа эзэмшигчдийн тэрш эрхийн байдлыг тунхагласан. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчид бүгд саналаа хэлэх, асуулт тавих, санал өгөх, тэдгээрийг хурлын тэмдэглэлд тусгуулах боломжоор тэнцүү хангагдана.</p> <p>Хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон цахим хосолсон хэлбэрээр оролцож цахим санал өгөх систем, саналын хуудсаар эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгөх</p>	2	

		боломжоор бүрэн хангаж ажилладаг. Хурлын үеэр санал, асуулга нээлттэй байсан бөгөөд хувьцаа эзэмшигчид чөлөөтэй асуулт асууж, банкны зүгээс хобогдох мэдээлэл, тайлбарыг хургуулж ажилладаг.	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэрэгжүүлсэн	<p>Голомт банк нь сонирхлын зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай гэрээ хэлцэлийн чанараас хамаарч тус бүрийн журам (Зээлийн хорооны дурэм)-д тусгаж зохицуулсан байна. Харин банкны нэгдсэн байдлаар мөрдөх Сонирхлын зөрчлөөс сэргийлэх бодлогыг Банкны Засаглалын кодын хэсэг болгон тунхагласан. Мөн "Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх журам"-ыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байна.</p> <p>Мөн ТУЗ-ийн хэмжээн Аудитын хороогоор сонирхлын зөрчилтэй хэлцэлийг хянах, батлах, ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороогоор сонирхлын зөрчилтэй зээлийг хянах/батлах асуудлыг тусган зохицуулсан байна. Сонирхлын зөрчилтэй хэлцэлийг хэрхэн батлахад чиглэсэн бодлого журмын дагуу шийдвэрүүд гарсан эсэхийг Дотоод аудитын газраас баталгаажуулж тогтмол тайлагнадаг. Харин хөндлөнгийн аудитын байгууллагаас жилийн үйл ажиллагааг шалгахад нийт хэлцэлүүдийг хянаж, зохистой хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг баталгаажуулан дүгнэлтийг гаргадаг ба энэхүү мэдээллийг жилийн тайланда тусгаж олон нийтэд нээлттэй болгодог.</p> <p>Мөн Банкны цахим хуудсанд Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг банкны цахим хуудсанд байршуулсан байдаг.</p>
	ДҮН	10	100%
	НЭГДСЭН ДҮН	72	100%

-Оо-

Дүгнэлт

“Голомт банк” ХК нь Монголын Хөрөнгийн Биржээс баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу нийт 9 бүлэг бүхий 36 асуулгаар, анх удаа өөрийн компанийн үнэлгээг гүйцэтгэлээ.

“Голомт банк” ХК-ийн үнэлгээний нийт оноо 72 үнэлгээний хувь 100% буюу засаглал хэвийн эрсдэлгүй байна. Хувьцаат компани болсонтой холбоотой засаглал, мэдээллийн нээлттэй ил тод байдал, хувьцаа эзэшигч, олон нийтэд хүргэх ёстой тайлан, мэдээ мэдээллийг шинэчлэх, сайжруулах шаардлагатай болсон бөгөөд энэхүү үнэлгээг гүйцэтгэснээр бидний анхаарал хандуулан ажиллах ёстой ажлуудыг улам нарийвчлан гаргаж өгч буй нь их хэрэгцээтэй байна.

Үнэлгээний үр дүнд “Голомт банк” ХК нь компанийн засаглалыг сайжруулах хүрээнд 2025 онд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Засаглалын баримт бичигтэй холбоотойгоор:
 - Засаглалын кодексыг шинэчлэх,
 - ТУЗ-ийн ажлын албаны журмыг шинээр боловсруулах,
 - Хувьцаа эзэмшигчтэй харилцах журам шинээр боловсруулах,
 - Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг шинээр боловсруулах.
2. Мэдээллийн нээлттэй ил тод байдлын хүрээнд:
 - www.golomtbank.mn цахим хуудсанд “Хувьцаа эзэмшигчдэд” зориулсан буланг үүсгэх, агуулга, мэдээллийг сайжруулах,
 - Компанийн засаглалтай холбоотой баримт бичиг, дүрэм журмыг цахим хуудсаар нийтлэх.
 - Мэдээллийн ил тод байдлын журмыг батлуулах.

Тайланг хянасан:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго

Бэлтгэсэн:

ТУЗ-ийн ажлын алба, мэргэжилтэн Б.Мишээл

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН”

Нотлох баримт бичгийн жагсаалт:

1. Голомт банк - Засаглалын кодекс
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааны журам
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
4. ТУЗ-Аудитын хорооны дүрэм
5. ТУЗ-Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм
6. ТУЗ-Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрэм
7. ТУЗ-Нэр дэвшүүлэх хорооны дүрэм
8. Эрсдэлийн удирдлагын газрын дүрэм
9. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо
10. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах дотоод журам
11. Компанийн бүтэц
12. Хүний нөөцийн бодлого
13. Code of Conduct
14. Цалин хөлсний журам
15. Ажилтанд нийгэм ахуйн хөнгөлөлт үзүүлэх, тэтгэмж олгох журам
16. Сургалт хөгжлийн журам
17. Салбар нэгжи н гүйцэтгэлийг үнэлэх журам
18. Төвийн нэгжийн гүйцэтгэлийг үнэлэх журам
19. Комплаенсийн бодлого
20. МУТСТ үйл ажиллагааны журам
21. Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам
22. Шүгэл үлээх заавар
23. 2025.04.17 ХЭХ тайлан/хурлын тэмдэглэл
24. Голомт банк - Цахим хаяг <https://golomtbank.com/>
25. 2024 оны Жилийн тайлан
<https://golomtbank.com/wp-content/uploads/2024/05/Annual-Report-2023-mng.pdf>
26. 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлан
<https://golomtbank.com/about-bank/sustainable-development>
27. ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга (мэдлэг туршлага, ур чадвар)
<https://golomtbank.com/investor-relations/board-of-directors>